

1. Шилжин ирсэн иргэд хүүхдээ цэцэрлэгт хэрхэн хамруулах вэ?

Нийслэлийн цэцэрлэгт хүүхдээ хамруулах хүсэлтийг цахимаар илгээхийн тулд амьдарч буй хороо, дүүрэгтээ бүртгүүлж, улсын бүртгэлийн хаягийг 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 17:00 цагаас өмнө шилжүүлэх шаардлагатай.

2. Аппликэйшн байхгүй бол хүүхдээ яаж бүртгүүлэх вэ?

Та өөрт ойр байрлах төрийн өмчийн цэцэрлэг дээр очиж, дэмжих багийнхнаас дэмжлэг авч хүсэлтээ илгээх боломжтой. (Хүүхдийн болон асран хамгаалагчийн бичиг баримтаа авч очно.)

3. Түр оршин суугч бол яах вэ?

Нийслэлийн цэцэрлэгт хүүхдээ хамруулах хүсэлтийг цахимаар илгээхийн тулд амьдарч буй хороо, дүүрэгтээ бүртгүүлж, улсын бүртгэлийн хаягийг элсэлтийг зохион байгуулах хугацаанаас өмнө шилжүүлэх шаардлагатай.

4. Хувийн цэцэрлэгт өгөх гэж байгаа бол хаягаа шилжүүлэх шаардлагатай юу?

“Нэмэлт элсэлт” авахаар хүсэлтээ Боловсролын хэлтэстээ гаргасан төрийн бус өмчийн цэцэрлэг нь тогтоосон хамран сургах тойргийнхоо хүүхдийг элсүүлэхэд хувьсах зардлын нэмэлт боломжийг эдлэх тул тухайн дүүргийн ажлын хэсгээс лавлана уу. Хэрвээ өмнө нь явж байсан хувийн цэцэрлэг нь хамтран ажиллахаар байгаа бол хаягийн шилжилт шаардлагагүй.

5. Өнгөрсөн жил орсон 2 настай хүүхдийг бүртгэх үү?

Та “Одоо суралцаж байгаа цэцэрлэгт үргэлжүүлэн хамруулна.” гэдэг сонголтыг хийгээрэй.

6. Өнгөрсөн хичээлийн жилд гэрийн ойролцоо цэцэрлэгт хамруулсан, энэ асуудал өөрчлөгдөх үү?

Та “Одоо суралцаж байгаа цэцэрлэгт үргэлжүүлэн хамруулна.” гэдэг сонголтыг цахимаар хийсэн тохиолдолд таны хүүхэд одоогийн сурч буй цэцэрлэгт үргэлжлүүлэн суралцах боломжтой.

7. Шилжиж ирж амжаагүй, байрны ордертой бол элсэлт хийх үү?

Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлтийг цахимаар илгээхийн тулд амьдарч буй хороо, дүүрэгтээ бүртгүүлж, улсын бүртгэлийн хаягийг 2022 оны 08 дугаар сарын 18-ны 17:00 цагаас өмнө заавал шилжүүлэх шаардлагатай.

8. Энэ жил хэдэн оны хүүхдүүд шинэ элсэлтэд орох вэ?

2023-2024 оны хичээлийн жилд 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 душаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдана.

9. Цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийн үйл ажиллагаа 100 хувь цахим хэлбэрт шилжсэн үү?

Е-Монголиа системээр хүсэлтийг хүлээн авна. Хэрвээ цахимаар бүртгүүлэх боломжгүй бол ойр байрлах төрийн өмчийн цэцэрлэгт өөрийн болон хүүхдийн бичиг баримттай очиж, цэцэрлэг дээрх дэмжих багийнхны тусламжтайгаар хүсэлтээ цахимаар илгээх боломжтой.

10. Өмнө нь явж байсан хувийн цэцэрлэг гарч ирээд байх юм, яах вэ?

“Одоогийн цэцэрлэгт үргэлжлүүлэн хамруулахгүй.” гэсэн сонголтыг цахимаар хийсэн тохиолдолд боломжит сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үе шаттай санал болгохыг анхаарна уу.

11. Хүүхэд аав, ээжийнхээ аль хаягаар явах вэ?

Хүүхдийн өөрийн хаягаар буюу одоо бүртгэлтэй улсын бүртгэлийн хаягтай хамгийн ойр төрийн үйлчилгээг үе шаттай санал болгоно. Та Е-Монголиа системээс хүүхдийн хаягийн мэдээллийг харах боломжтой.

12. Оршин суугаа хаяг дээр маань цэцэрлэгийн хүүхдийн тоо нь хэтэрчихвэл яах вэ? Хүртээмж ямар байгаа бэ?

Хүүхдийн хаягт хамгийн ойр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үе шаттай санал болгоно.

13. “Е-Монголиагаар” гэхээр заавал үнэмлэхийн хаягаар болчихоод байна. Хороон дээр очиж уулзахад хамгийн эхлээд үндсэн хаягтай хүүхдүүдээ авна гэх юм. Үүнийг яаж зохицуулах вэ?

Улсын бүртгэлийн ерөнхий газар дээр бүртгэлтэй хүүхдийн хаягт үндэслэн хамгийн ойр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үе шаттай санал болгох учир шилжилт хөдөлгөөнийг 08 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө амьдарч буй хороондоо хийлгэх шаардлагатай.

14. Хороо болгон харилцан адилгүй мэдээлэл өгч байна, яах вэ?

Элсэлтийн мэдээллийг E-Mongolia болон parent.edu.mn, 75778080, төрийн үйлчилгээний 11-11 дугаарт хандан авах боломжтой. Мөн дүүрэг бүр дээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа тул та гэрийн ойролцоох төрийн өмчийн цэцэрлэгт хандан дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

15. Байр түрээсэлж байгаа, хороон дээрээ бүртгэлгүй хүүхдээ хамруулахын тулд ямар бичиг баримт бүрдүүлэх вэ?

Холбогдох материалыг бүрдүүлэн амьдарч буй хороондоо бүртгүүлэх боломжтой.

16. Ямар тохиолдолд 2-р шатны элсэлтийн бүртгэлд хамрагдах боломжтой вэ?

Цэцэрлэгт бүртгэлгүй хүүхэд болон 1-р шатанд хүсэлтээ илгээж амжаагүй эцэг эх, асран хамгаалагчид хүсэлтээ цахимаар илгээн нийслэлийн цэцэрлэгт хамрагдах боломжтой.

17. Эхний шатны хүсэлтээр цэцэрлэгт хуваарилагдсан ч гэрээ байгуулаагүй тохиолдолд дахиж цэцэрлэгт хамрагдах хүсэлт гаргаж болох уу?

Цэцэрлэгтэй гэрээ байгуулаагүй ба цэцэрлэгт бүртгэл хийлгээгүй тохиолдолд хүсэлт гаргах боломжтой.

18. Ажлын газрын хаягийн оройлцоох цэцэрлэгт хүүхдээ өгөх хүсэлтэй байна. Хэрхэн шийдвэрлэх вэ?

Улсын бүртгэл дээр бүртгэлтэй хаягаар 2-5 настай хүүхдийг хамгийн ойр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үе шаттай санал болгох учир хаягийн шилжилт хөдөлгөөнийг харьяа хороонд заавал бүртгүүлэх шаардлагатай.

19. Хүүхдээ өмнөх хичээлийн жилд хувийн цэцэрлэгт явуулсан. Энэ жил төрийн өмчийн цэцэрлэгт явуулах хүсэлтэй. Өмнөх цэцэрлэгээсээ хасалт хийлгэхийн тулд хаана, хэнд хандах вэ?

Цэцэрлэг дээр очиж хасалт хийлгэнэ. Хүсэлт илгээхдээ үргэлжлүүлэн суралцахгүй гэсэн сонголт хийнэ. Ингэснээ хүүхдийг хамгийн ойр цэцэрлэгт харьяалуулах асуудлыг (ESIS.EDU.MN)-ээр тогтоож санал болгоно.

20. 2022-2023 оны хичээлийн жил цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг 3 үе шаттай зохион байгуулсан, энэ жил ямар зохион байгуулалтаар явуулах вэ?

2023-2024 оны хичээлийн жилийн бүртгэл, элсэлтийг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

1 дүгээр үе шатад Үндсэн хаягтай хүүхэд цэцэрлэгт хамрагдана.

2 дугаар үе шатад Түр оршин суугчийн хүүхэд хамрагдана.

АЛХАМЧИЛСАН ЗААВАР

▶ 8-Р САРЫН 01-20
9-Р САРЫН 11-20
Нийслэлийн
цэцэрлэгт хамрагдах
хүсэлт хүлээн авах

АЛХАМ 1

▶ 8-Р САРЫН 21-25
9-Р САРЫН 20-22
Хариу өгөх

АЛХАМ 2

▶ 9-Р САРЫН 01
9-Р САРЫН 22-ООС ХОЙШ

Суралцагчдын бүртгэлийг
баталгаажуулж, гэрээ
байгуулах

АЛХАМ 3

